



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022 06 02 № 05/7686  
таний -ны № -т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Зундуин Гантогоо, Төрийн захирагааны удирдлагын газрын төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Баатаржавын Дэлгэрмаа нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж уг хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

Харин нэр дэвшигч З.Гантогоо Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заасан Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангахгүй, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3-т “энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх”, 43.6-д “Энэ хуульд заасан журмыг зөрчиж төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно” гэж заасан байх тул нэр дэвшигчийг Төрийн албаны тухай хууль, бусад салбарын хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавьж, Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



1422003011857